

**АГААР ЦЭВЭРШҮҮЛЭГЧ  
+ БАКТЕРИ УСТГАГЧ  
+ ИОНЖУУЛАГЧ**



---

**Ашиглалтын заавар**

**AE-180**

Энэхүү бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө ашиглалтын заавартай сайтар танилцана уу.

# АГУУЛГА

1.	Техникийн үзүүлэлтүүд	3
2.	Цэвэршүүлэгчийн онцлог	3
3.	Бүтээгдэхүүний зураг	5
4.	Ажиллуулахад бэлтгэх	6
5.	Шүүлтүүрийг цэвэрлэх зөв дадал	7
6.	Ажиллагааны заавар	8
7.	Анхаарах зүйлс	10
8.	Эвдрэлийг тодорхойлох	14

# 1. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бүтээгдэхүүний нэр	Агаар цэвэршүүлэгч
Хүчдэлийн хэмжээ	АС 220V-240V
Давтамжийн хэмжээ	50/60Гц
Цахилгаан	40W

# 2. ЦЭВЭРШҮҮЛЭГЧИЙН ОНЦЛОГ

## Хүйтэн каталист шүүлтүүр

1. Хүйтэн каталист нь хэт ягаан туяаны гэрэл, нарны гэрэл, өндөр температур, даралт зэрэг гадны нөлөөгүй энгийн амьдрах орчны каталист нөлөөг үзүүлнэ.
2. Энэ нь хүчилтөрөгчтэй урвалд орох формальдегид, аммони, бензин, TVOC, гидроген сульфид болон бусад хорт хийг задлан, ус ба карбон диоксидод хувиргадаг.
3. Хүйтэн каталист нь задлах процессын үеэр өөрөө урвалд ордоггүй учраас 5 хүртэл жил ашиглагдах боломжтой.
4. Каталистын үндсэн орц нь хүнс, анагаахын бодис байдаг. Тиймээс бүтээгдэхүүн нь хоргүй, зэвэрдэггүй, галд үл шатамхай. Энэ нь энгийн нөхцөлд ажиллаж, зөвхөн ус ба карбон диоксид үүсгэдэг.
5. Хүйтэн каталист нь мод, тавилга, ханын цаас, хивс, орны бүтээлгээс ялгарах формальдегид, аммони, бензин, TVOC, гидроген сульфид болон бусад хорт бодисыг цэвэрлэхэд хэрэглэгдэнэ.

## **Идэвхжүүлсэн нүүрсэн шүүлтүүр**

- Эсийн идэвхжүүлттэй нүүрсэн шүүлтүүр нь өндөр үр дүнтэй бодисуудыг агуулдаг. Энэ нь шингээлт, тоос цуглуулалтын өндөр чадвартай.

## **Нян бактерийн эсрэг шүүлтүүр**

- Нян бактерийн эсрэг бодистой 5 микроны шүүлтүүр нь агаар дахь нян бактерийг үр дүнтэйгээр устгана.

## **Өндөр үр дүнтэй ХЕПА шүүлтүүр**

- ХЕПА шүүлтүүрийн нягтрал нь 0,01 микрон бөгөөд 0,01 микрон болон түүнээс том хэсгүүдийг 99% ба түүнээс дээш хувиар шүүх чадвартай. Тоос, тоосонцор, хөгц, нян бактер, аллерги үүсгэгч болон бусад жижиг өчүүхэн хэсгүүд ХЕПА шүүлтүүрийг давж чадахгүй.


## **Сөрөг цэнэгтэй ион ялгаруулагч**

- Ионжуулагч нь их хэмжээний анион буюу сөрөг цэнэгтэй ион ялгаруулж сөрөг цэнэгтэй хүчилтөрөгчийг үүсгэснээр агаар дахь тоос, тоосонцор, нян бактер, утаа зэрэг эерэг цэнэгт жижиг биетүүдийг өөрт татаж цуглуулдаг.

## **Хэт ягаан туяат ариутгалын гэрэл**

- 245 нм хэт ягаан туяаны гэрэл нь төрөл бүрийн нян бактерийг устгаж ариутгана. Хэт ягаан туяаны бактери устгагч гэрэл нь агаарыг цэвэршүүлж, утаа, хөгцнөөс үүсэх үнэрийг арилгана. Түүнчлэн, өрөөн дэх агаарыг цэвэршүүлэхийн сацуу вирус тархахаас сэргийлэх тодорхой хэмжээний сөрөг ион үүсгэдэг.

### 3. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗУРАГ



1	Дэлгэц	7	Сөрөг цэнэгт ион	13	Хойд тал
2	Хянах самбар	8	Унтлага тохиргоо		
3	Асаах/унтраах	9	Нүүрэн тал		
4	Ариутгах	10	Дунд хайрцаг		
5	Цагны тохиргоо	11	Бариул		
6	Сэнсний хурд	12	Агаар гадагшлалт		

## 4. АЖИЛЛУУЛАХАД БЭЛТГЭХ



Нүүрний тагийг доод талаас татаад, доош нь сугалж ав.



Гогцоог эргүүлж шүүлтүүрийн хоёр хавтанг татаж ав.



Тээвэрлэлтийн уутнаас шүүлтүүрүүдийг гарга.



Бүтээгдэхүүний дотор талд Шүүлтүүр 2-г буцааж хий.

Анхаар: Тэмдэгтэй тал нь өөр лүү чинь харсан эсэхийг нягтлах.



Бүтээгдэхүүний дотор талд Шүүлтүүр 1-г буцааж хий.

Анхаар: Тэмдэгтэй тал нь өөр лүү чинь харсан эсэхийг нягтлах.



Шүүлтүүрүүдийг зөв байрлуулсан эсэхийг нягтлах. Шүүлтүүрүүдийг хийгээд, гогцоонуудыг эргүүлэх.



Нүүрэн талыг суурилуулахдаа дээд хэсгийг нь ховил руу хийгээд таглана. Нүүрэн тал нь өөртөө байрласан соронзонгоор тогтоно.

## 5. ШҮҮЛТҮҮРИЙГ ЦЭВЭРЛЭХ ЗӨВ ДАДАЛ



Шүүлтүүрийн ашиглах хугацааг уртасгахын тулд хортой хий, үнэрийг арилгаж бактерийг устгахаар үе үе нарны шууд тусгалд тавих нь зүйтэй.



Гажилт болон галаас хамгаалж шүүлтүүрийг өндөр хэмд ойртуулж болохгүй.

## 6. АЖИЛЛАГААНЫ ЗААВАР



Энэ бүтээгдэхүүн нь жижиг дугуй батерей бүхий алсын удирдлагаар ажилладаг. Хэрэв алсын удирдлагыг удаан хугацааны турш ашиглахгүй бол батерейг салгана уу.

Анхаарах: Удирдлаганы товчнууд нь их биен дээрх ижил товчнуудтай адил үүрэгтэйгээр ажиллана.



Power товчин дээр дарахад дижитал дэлгэцний дугуй хэсэг анивчиж, төхөөрөмж ажиллахад бэлэн горимд шилжинэ.



Timer товчин дээр дараад зүүн талын нэмэх хасах товчоор ажиллах цагаа (1-12) тохируулна. Тухайн хугацаа өнгөрөхөд төхөөрөмж өөрөө унтарна.



Speed control товч дарснаар уг төхөөрөмжийн цэвэршүүлэгч ажиллана. Дижитал дэлгэцэн дээр цэвэршүүлэх хурд харагдах ба бага, дунд, өндөр гэсэн хэмнэлд шилжүүлж болно.





Sleep товчин дээр дарахад төхөөрөмж хамгийн бага хурдаар ажиллана. Speed болон Sleep товнууд нь харилцан давхцахгүй байдлаар ажилладаг. Нэг нь асаалттай үед нөгөөх нь унтрана.



Anion товчийг дарахад сөрөг ионжуулагч ажиллана. Anion бичиг дэлгэцэн дээр харагдана.



Sterilize товчийг хэт ягаан туяаны гэрлийг ажиллуулах үед дарна. Sterilize бичиг дэлгэцэн дээр харагдана.

## 7. АНХААРАХ ЗҮЙЛС

Төхөөрөмжийг ажиллуулж эхлэхээсээ өмнө энэхүү ашиглах зааврыг бүрэн уншиж, цаашид хэрэглэхээр хадгална уу.



### Аюултай

- Цахилгаанд цохиулах болон галаас хамгаалахын тулд төхөөрөмжийг үргэлж хуурай байлгаж, ус болон бусад шингэн зүйлсээс хол байлгана уу.




### Анхааруулга

1. Төхөөрөмжийн ард байрлах шошгон дээр заасан хүчдэлтэй цахилгааны залгуурын хүчин чадал тохирч байгаа эсэхийг шалгана уу.



2. Хэрэв залгуурын утас гэмтсэн байвал төхөөрөмжийг ашиглахаа зогсоож засварчинд хандана уу.



3. Агаарын орох, гарах хэсгийг ямар нэгэн зүйлээр таглаж болохгүй.



4. Аюулгүй байдлын үүднээс хүүхэд болон ажиллуулах хангалттай мэдлэггүй хүнээр төхөөрөмжийг бие даан ажиллуулахыг бүү зөвшөөр.




## Сануулга

1. Энэ бүтээгдэхүүн нь өдөр тутмын сэнс, тоос цэвэрлэгч, хиншүү сорогчын үүргээр ашиглагдах ёсгүй.



2. Цахилгааны залгуурын бүрэн бүтэн байдалд анхаарал тавих. Эс бөгөөс залгуур халж, гал гарах эрсдэлтэй.

3. Төхөөрөмж хуурай, хөдөлгөөнгүй, хавтгай гадаргуу дээр байрлах ёстой.



4. Хамгийн багадаа хоёр тал болон хойд талд нь 20 см, дээд талд нь 30 см хоосон зайтай байх.



5. Дээр нь суух, эсвэл эд зүйлс тавихыг хориглоно.

6. Төхөөрөмж дээр конденсаци үүсэхээс сэргийлж, түүнийг шууд агааржуулагчийн (air conditioner) доор байрлуулж болохгүй.
7. Төхөөрөмжийг хатуу зүйлээр цохих, тогшихыг хориглоно. (Ялангуяа агаар орох хэсэг болон нүүрэн талыг)
8. Төхөөрөмжийг шавьж үргээгч шингэн цацсан үед болон шатамхай хийгээр дүүрсэн газар ашиглаж болохгүй.



9. Төхөөрөмжийг шингэн хий ашигладаг төхөөрөмж, халаагч төхөөрөмж, зуухны ойролцоо ашиглаж болохгүй.

10. Ашигласны дараа болон цэвэрлэхдээ залгуурыг салгаж байх.
11. Төхөөрөмжийн дотор урвал үүсэхээс сэргийлж температурын хэлбэлзэл ихтэй өрөөнд ашиглаж болохгүй.
12. Энэ бүтээгдэхүүн нь энгийн ажиллагааны нөхцөлтэйгээр гэр ахуйн хэрэглээнд зориулан бүтээгдсэн болно.



13. Төхөөрөмжийг чийглэг болон өндөр температуртай орчинд ашиглаж болохгүй. (ариун цэврийн өрөө, гал тогоо гэх мэт)



14. Хүүхдийг удирдлагаар тоглуулж болохгүй.

## 8. ГЭМТЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

Асуудал	Шийдэл
Агаар гарах хэсгээс агаар гарахгүй байх	Төхөөрөмжийг асаасан эсэх, цахилгаанд залгагдсан эсэхийг нягтлах
Гарч буй агаарын хэмжээ өмнөхөөсөө мэдэгдэхүйц буурсан	Шүүлтүүр бохирдсон тул цэвэрлэх буюу солих. Тоос болон бусад биетийг салгахын тулд шүүлтүүрийг бага зэрэг сэгсэрч болно.
	Шүүлтүүр ууттайгаа байна. Баглаа боодлыг нь салгаж авах.
Төхөөрөмжийг удаан хугацаагаар ажиллуулсан ч агаарын чанар мэдэгдэхүйц сайжрахгүй байх	Шүүлтүүрийн давхаргыг суурилуулах дарааллыг шалгах
	Шүүлтүүр ашиглалтгүй болсон тул түүнийг шинээр солих
Шүүлтүүрүүдийг хэзээ шинээр солих ёстой вэ?	Эхний шүүлтүүр: Гадаргуу нь бохир, өнгөтэй гандсан. Хүйтэн каталистын жижиг нүхнүүд бөглөрсөн болон нүүрсний өнгө мэдэгдэхүйц өөрчлөгдсөн. Ашиглах хугацаа: 8-14 сар.
	Хоёрдох шүүлтүүр: Цагаан ХЕПА шар, хар, хөгцтэй болсон. Ашиглах хугацаа: 8-14 сар.
	Сануулга: Шүүлтүүрийн ашиглах хугацаа нь агаарын чанар болон ашигласан хугацаанаас хамаарна



# ЭКО АГААР, ЭРҮҮЛ АМЬДРАЛ